ЗАВХАН АЙМГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАР
81090 Улиастай, Завхан аймаг
Утас/Факс:7046-38-20
И-Мэйл: Ndaatgal.za.gov.mn

2024.12.10 № 571

танай________________-ны №______________-т

НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗАРТ

Тус газрын 2024 оны хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлтийг гаргаж хүргүүлэв.

Хавсралт 17 хуудастай.

ДАРГА С.НЯМЖАВ

My doc Zavkhan A-5

ТОВЪЁОГ

| Д/д | Товч утга | Хуудасны тоо | Хуудасны дугаар |
|---|---|---|---|
| 1 | Засгийн газрын тогтоол | 1 | 1 |
| 2 | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол | 1 | 2 |
| 3 | Хөдөлмөр, нийгмийн хамгааллынг сайдын тушаал | 3 | 3 |
| 4 | Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын албан даалгавар | 1 | 6 |
| 5 | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал | 11 | 6 |

**ЗАВХАН АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗАРТ ХОЛБОГДОХ ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТ**

2024.12.09

| № | Шийдвэрийн дэс дугаар | Зүйл заалтын дэс дугаар | Шийдвэрийн нэр, дугаар агуулга | Биелэлт | Үнэлгээ /Хүчингүй болсон, хяналтаас хасуулсан тухай санал/ |
|---|---|---|---|---|---|
| **Нэг: Засгийн газрын тогтоол** | | | | | |
| 1 | 83 | 2024.02.28 | Журам батлах, хавсралтад өөрчлөлт оруулах тухай | Засгийн газрын 2024 оны 02 дугаар сарын 28-ний өдрийн "Журам батлах, журмын хавсралтанд өөрчлөлт оруулах тухай" 83 дугаар тогтоол, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2024 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн "Зөвлөмж хүргүүлэх тухай" 01/570 дугаар зөвлөмжийн дагуу сумдын 17 төрийн захиргааны албан хаагчид 111546.2 мянган төгрөгний мөнгөн урамшууллыг олгосон. | |
| 2 | 75 | 2024.09.11 | Аргачлал батлах тухай | 2025 оны 01 дүгээр сарын 01-ны өдрөөс хэрэгжих “Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай” аргачлалыг нийт байцаагч ажилтнуудад хүргүүлж мэдээллээр хангаж ажилласан. | |
| 3 | 109 | 2024.10.02 | Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай | Засгийн газрын 2024.10.02-ны өдрийн “Ёс зүйн хэм хэмжээ батлах тухай” 109 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан тушаал эрхэлдэг “Төрийн албан хаагчийн ёс зүйн хэмжээ”-г нийт байцаагч ажилтнуудад танхимаар болон цахим сургалтын зохион байгуулж, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Ёс зүйн хэм хэмжээг бүх ажилтнуудад өгч ёс зүйн зөрчил гаргалгүй ажиллахыг сануулан ажилласан.<br>Нийт байцаагч ажилтнуудад газрын дарга С.Нямжав " Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль", "Төрийн хаагчийн ёс зүйн хэм хэмжээ" сэдвээр 2 удаагийн сургалт зохион байгуулсан. | |
| *Засгийн газрын тогтоолын хэрэгжилтын дундаж хувь: 100%* | | | | | |

| Хоёр: Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | 1 | 2024.03.05 | Журам батлах тухай | Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2024.03.05-ний өдрийн "Журам батлах тухай" 01 тоот тогтоолыг сумдын болон газрын ажилтан албан хаагчдад хүргүүлэн, хэрэгжүүлж ажилласан. | |
| 2 | 6 | 2024.09.06 | Журам батлах тухай | Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2024.09.06-ы өдрийн 06 тоот тогтоолын дагуу "Ажил олгогчид үзүүлэх ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт"ийн журмыг нийт байцаагч ажилтнуудад ажилтнуудын нэгдсэн группээр дамжуулан хүргэсэн журмын хэрэгжиж эхлэх хугацаа, шимтгэлийн хөнгөлөлтийн хувь хэмжээ, нөхцөл болзолын талаар мэдээлэл өгч ажилласан. | |
| 3 | 7 | 2024.09.06 | Журам батлах тухай | Нийгмийн даатгалын Үндэсний зөвлөлийн 2024.09.06-ы өдрийн 07 тоот тогтоолын дагуу "Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалгаалах өвчний даатгалын сангаас олгох шимтгэлийн хөнгөлөлт, чөлөөлөлт"ийн журмыг нийт байцаагч ажилтнуудад ажилтнуудын нэгдсэн группээр дамжуулан хүргэсэн журмын хэрэгжиж эхлэх хугацаа, шимтгэлийн хөнгөлөлтийн хувь хэмжээ, нөхцөл болзолын талаар мэдээлэл өгч ажилласан. Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтын байгууллагыг сонгон шалгаруулах, сургалт зохион байгуулах, тайлагнах журмыг танилцуулсан. | |
| 4 | 9 | 2024.11.08 | Төлөвлөгөө батлах тухай | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил, шинэ хоршоо хөдөлгөөний хүрээнд малчдын нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор үйлдвэрлэлийн осол мэргэжилээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалтын төлөвлөгөөний дагуу нийт сумдаас шинэ хоршоо хөдөлгөөнд хамрагддаг хоршооны судалгааг авсан ажиллаж байна. Мөн жижиг дунд үйлдвэрт ажилладаг хувиараа хөдөлмөр эрхлэгдчийн тоо судалгаа, сургалтад хамрах боломжийг судалж байна. Хамтран ажиллах сургалт зохион байгуулах мэргэжлийн байгууллагуудын мэдээллийг авч ажиллаж байна. | |
| *Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоолын дундаж хувь: 100%* | | | | | |

| Гурав: Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын тушаал | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 1 | А/202 | 2023.12.25 | Журам батлах тухай | Цэргийн алба хаагч өндөр насны тэтгэвэр тогтоолгох бол цэргийн алба хаасан хугацааны шимтгэлийг нөхөн төлүүлэхээс гадна ЦАХТТ тухай хуулийн 22 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан заасан хөдөлмөрийн чадвар алдсаны болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр тогтоолгох бол тухайн иргэний авч байсан цалин хөлс, түүнтэй адилтгах орлогыг итгэлцүүрээр өсгөсөн дүнгээс тэтгэврийн даатгалын шимтгэлийг нь ажил олгогчийн төлөх хувь хэмжээгээр тооцож нийгмийн даатгалын санд төлүүлнэ. Журмын дагуу 1 тэтгэвэр авагчийн 1774.4 мянган төгрөгийг нэхэмжлэн тэтгэврийг тогтоон олгосон. | |
| 2 | А/225 | 2023.12.28 | Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох тухай | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023.12.28-ний өдрийн "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх олгох тухай" А/225 тоот тушаалыг хэрэгжүүлж Газрын даргын 2024.03.04"ний өдрийн "Цалин шинэчлэн тогтоох тухай" Б/14 тоот тушаалаар Улсын байцаагчийн эрх шинээр авсан 2 байцаагчийн цалингийн шатлалыг 2024.03.01-с ТЗ-7 шатлалаар өөрчлөн тогтоож сар бүр олгож байна. | |
| 3 | А/226 | 2023.12.28 | Нийгмийн даатгалын байцаагчийн эрх сэргээх, баталгаажуулах тухай | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023.12.28-ний өдрийн "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх сэргээх, баталгаажуулах тухай" А/226 тоот тушаалыг хэрэгжүүлж Газрын даргын 2024.03.04"ний өдрийн "Цалин шинэчлэн тогтоох тухай" Б/14 тоот тушаалаар Улсын байцаагчийн эрх шинээр авсан 2 байцаагчийн цалингийн шатлалыг 2024.03.01-с ТЗ-7 шатлалаар өөрчлөн тогтоож сар бүр олгож байна. | |
| 4 | А/227 | 2023.12.28 | Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх түтгэлзүүлэх, эрх хүчингүй болгох тухай | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2023.12.28-ний өдрийн "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн эрх түтгэлзүүлэх, хүчингүй болгох тухай" А/227 тоот тушаалыг хэрэгжүүлж Улсын байцаагчийн эрх түтгэлзүүлэх 1 байцаагчийг эрх авах хүртэл ТЗ-9 шатлалаар сар бүр олгож байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 5 | А/39 | 2024.02.28 | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээг батлах тухай | Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөлөөс баталсан хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа хэрэгжүүлэх нэгдсэн удирдамж, зардлын жишиг хэмжээ, үйл ажиллагааны хэрэгжилтийг зохион байгуулж, тайлагнан ажиллаж байна. | |
| 6 | А/40 | 2024.03.01 | Журам батлах тухай | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.03.01-ний өдрийн "Журам батлах тухай" А/40 тоот тушаалын хавсралтаар батлагдсан "Нийгмийн даатгалын улсын байцаагчийн журам"-ийг хэрэгжүүлэн газрын албан хаагчдад танилцуулан, сумдын байцаагч, мэргэжилтнүүдэд Газрын даргын 2024.03.22-ний өдрийн 210 тоот албан бичгээр хүргүүлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажилласан. | |
| 7 | А/44, А/40 | 2024.03.06 | Маягтын загвар, аргачлал батлах тухай | "Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны маягтын загвар", "Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн анхан шатны бүртгэлийн маягт хөтлөх аргачлал"-ийн дагуу ажил олгогч, даатгуулагч, иргэдэд мэдээлэл өгч хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 8 | А/53 | 2024.03.22 | Дотоод аудитын тайлан батлах, ажил эрчимжүүлэх тухай | Шилэн дансны тухай хууль, журмын хэрэгжилтийг бүрэн биелүүлж, мэдээллийг шилэн дансны цахим хуудасанд хуульд заасан хугацаанд байршуулан ажиллаж байна. | |
| 9 | А/80 | 2024.04.18 | Мэргэшлийн зэрэг олгох тухай | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.04.18-ний өдрийн "Мэргэшлийн зэрэг олгох тухай" А/80 тоот тушаалаар Тэргүүлэх мэргэшлийн зэрэг авсан-3, Зөвлөх мэргэшлийн зэрэг авсан-19 нийт 22 байцаагчид хууль тогтоомжийн дагуу мэргэшлийн зэргийн нэмэгдлийг сар бүр олгон ажиллаж байна. | |
| 10 | А/87 | 2024.04.23 | Тушаалын хавсралтад нэмэлт өөрчлөлт оруулах тухай | “Хөдөлмөрийн хортой нөхцөл”-ийн 2.34 дэх хэсэгт Хүнд даацын авто машины жолооч /Белаз 100.1 тн-оос их/, “Хөдөлмөрийн халуун нөхцөл”-ийн 3.1 дэх хэсэгт Зуухны цехийн тоосны системийн машинч, турбин цехийн турбины машинч нэмэгдсэн тушаалыг нийт байцаагч ажилтнуудад хүргүүлж мэдээллээр хангасан. Дээрхи нөхцлүүдээр тэтгэвэр тогтоолгосон иргэн байхгүй болно. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11 | А/113 | 2024.05.31 | Журам батлах тухай | Нийгмийн даатгалын үйлчилгээ үзүүлэхэд мэдээллийн нэгдсэн санал бүртгэгдээгүй баримт бичгийг ажил олгогч болон даатгуулагчаас цаасан болон цахим хэлбэрээр авч бүртгэж байна. Мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл үнэн зөв бүртгэх баяжуулах буруу бүртгэгдсэн мэдээллийг засах шинэчлэх тал дээр анхаарч ажиллаж байна.<br>Нийгмийн даатгалын мэдээллийн санг ашиглан ажил олгогч иргэд даатгуулагчдад лавлагаа тодорхойлолт акт тогтоолтын хуудсыг цахим эсвэл цаасан хэлбэрээр олгож үйлчилгээ үзүүлж байна.<br>Нийгмийн даатгалын байгууллагын албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад заасан мэдээлэлүүдийг албаны нууцад хамааруулан гуравдагч этгээдэд өгөхгүй байх тал дээр анхаарч ажиллаж байна. | |
| 12 | А/29 | 2024.10.08 | Журамд өөрчлөлт оруулах тухай | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.10.08-ний өдрийн "Журамд өөрчлөлт оруулах тухай" А/29 тоот тушаалыг хэрэгжүүлэн Газрын даргын 2024.11.01-ний өдрийн "Албан хаагчдын мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах тухай" А/39 тоот тушаалаар газрын зөвлөх мэргэшлийн зэрэгтэй 18 албан хаагчид 20 хувиар, тэргүүлэх мэргэшлийн зэрэгтэй 2 албан хаагчид 15 хувиар өөрчлөн тогтоож 2024.10.01-ний өдрөөс эхлэн олгож байна. | |
| 13 | А/37 | 2024.10.17 | Ажлын хэсэг байгуулж удирдамж батлах тухай | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.10.17-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах, удирдамж батлах тухай" А/37 тоот тушаалыг Улсын байцаагчийн эрх олгох, баталгаажуулах шалгалтад орох 15 байцаагчид Zoom болон танхимаар танилцуулан ажилласан.<br>Түүнчлэн шалгалтад орох байцаагчдад ажлын цагийг зохицуулж, сумдын байцаагчдыг аймагт ирүүлэн нэгдсэн 5 хоногийн сургалт хийж, шалгалтад бэлдэх байр, хоол болон бусад нөхцөл боломжийг бүрдүүлж ажилласан. | |
| *Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаалын дундаж хувь: 100%* | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **Дөрөв: Хөдөлмөр Нийгмийн хамгааллын сайдын албан даалгавар** | | | | | |
| 1 | 1 | 2024.07.22 | Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэх, сахилга, хариуцлагыг сайжруулах тухай | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024.07.22-ний өдрийн 01 тоот албан даалгаварын хүрээнд Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын А/138 тоот "Төлөвлөгөө батлах тухай" тушаал гарсан бөгөөд Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж, төлөвлөгөөний биелэлтийг Нийгмийн даатгалын Ерөнхий газарт 3 удаа хүргүүлэн ажилласан. | |
| *Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын албан даалгаварын дундаж хувь: 100%* | | | | | |
| **Тав: Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаал** | | | | | |
| 1 | А/169 | 2023.12.18 | Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2023.12.28-ний өдрийн "Зохион байгуулалтын арга хэмжээ авах тухай" А/169 тоот тушаалаар 2024.01.01-ний өдрөөс Нийгмийн даатгалын хэлтэс байсныг Нийгмийн даатгалын газар гэж өөрчлөн Улсын бүртгэлд бүртгүүлж, өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэглэх бланк /Хэвлэмэл хуудас/-ийг хийлгэн, байгууллагын тэмдэгийг шинэчлэн төрийн үйлчилгээг тасралтгүй хүргэн ажиллаж байна. | |
| 2 | А/02 | 2024.01.04 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хувиар батлах тухай | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 38732689.8 мянган төгрөг, зардлын төлөвлөгөө 117602323.8 мянган төгрөгөөр батлагдсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. | |
| 3 | А/03 | 2024.01.04 | Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хувиар батлах тухай | 2025 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын "Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарь батлах тухай" А/03 дугаар тушаалаар 1832883.5 мянган төгрөгний төсөв батлагдсан. Төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 4 | А/15 | 2024.01.25 | Төлөвлөгөө батлах тухай | 2024 оны 01 дугаар сарын 25-ний өдрийн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/15 дүгээр тушаалаар баталсан эрүүл мэндийн даатгалын сангийн орлого 805 501.0 мян.төгрөгийг сум тус бүрээр нь хувиарлан Газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 19-ны өдрийн "Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны орлогын төлөвлөгөөний хуваарь батлах тухай" А/07 тушаалаар хүргүүлсэн. | |
| 5 | А/20 | 2024.02.08 | Нээлттэй өгөгдөл байршуулах төлөвлөгөө, хувиар батлах тухай | Цахим хуудсанд байршуулах нээлттэй мэдээллийн жагсаалтын дагуу zavhan.ndaatgal.mn цахим хуудсыг хөгжүүлж жагсаалтын дагуу бүх мэдээллийг байршуулсан. Шаардлагатай бүх мэдээллийг холбогдох ажилчдаас авч байршуулсан бөгөөд цахим хуудсыг тухай бүрт нь шинэчлэн ажиллаж байна. Мэдээллийн самбарт барйшуулах мэдээллийн жагсаалтын дагуу холбогдох ажилчдаас мэдээллийг гаргуулан мэдээллийн самбарын мэдээллийг байршуулсан. Улирал болгон shilen.gov.mn цахим хуудсанд өөрийн газрын цахим хуудас болон мэдээллийн самбарт байрласан мэдээллүүдийн зураг линкийг оруулан үнэлгээ хийлгэн ажиллаж байна. | |
| 6 | А/35 | 2024.03.18 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хувиарт өөрчлөлт оруулах тухай | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 38732689.8 мянган төгрөг, зардалын төлөвлөгөө 1176122181.6 мянган төгрөгөөр батлагдсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. | |
| 7 | А/38 | 2024.03.25 | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн А/38 тоот тушаалаар баталсан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинэ бүрэлдэхүүнээр долоо хоног бүрийн пүрэв гаригт хурлыг зохион байгуулж даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 8 | Б/38 | 2024.04.02 | С.Нямжав-т цалинтай чөлөө олгох тухай | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2024.04.02-ний өдрийн "С.Нямжавт цалинтай чөлөө олгох тухай" Б/38 тоот тушаалыг хэрэгжүүлж 2024.04.02-2024.05.02-ний хооронд чөлөөтэй байх хугацааны цалин хөлсийг тооцон олгож ажилласан. | |
| 9 | Б/39 | 2024.04.02 | А.Мядагмааг түр орлон гүйцэтгэгчээр томилох тухай | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2024.04.02-ний өдрийн "А.Мядагмааг түр орлон гүйцэтгэгчээр томилох тухай" А/39 тоот тушаалыг хэрэгжүүлж Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэх хугацааны цалингийн зөрүүг тооцож олгосон. | |
| 10 | А/43 | 2024.04.02 | Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дугаар сарын 02-ны өдрийн "Даатгуулагчийн төрлийн код нэмж батлах тухай" А/43 тушаалын дагуу ажил олгогчид сурталчилан таниулж нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланд бүртгэх даатгуулагчийн төрлийн батлагдсан кодуудыг мөрдөн ажиллаж байна. | |
| 11 | А/47 | 2024.04.08 | Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хувиарт өөрчлөлт оруулах тухай | Засгийн газрын 2024 оны "Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 128 дугаар тогтоолоор албан тушаалын үндсэн цалин нэмэгдсэнтэй холбоотойгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын "Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" А/47 дугаар тушаалаар 1818372.5 мянган төгрөгний төсөв батлагдсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | А/48 | 2024.04.08 | Төлөвлөгөө батлах тухай | “Шударга байдлын үнэлгээ”-г сайжруулах арга хэмжээний 2024 оны нэгдсэн төлөвлөгөөний дагуу 3 арга хэмжээ бүхий 9 ажил үйлчилгээ явуулах дэд төлөвлөгөө гарган газрын даргаар батлуулсан. Тухайлбал:<br>1. Нийтийн мэдээллийн ил тод байдлын хуульд заасан мэдээллийг www.shilen.gov.mn сайтад бүрэн байршуулсан<br>2. Олон нийтийн цахим сүлжээ ( facebook) болон өөрийн www.zavhan.ndaatgal.mn хуудсанд мэдээллийг тухай бүр нь бүрэн байршуулсан.<br>3. “Авлигын шалтгаан, хор хөнөөл, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдэвт сургалтанд албан хаагчдыг танхим болон цахимаар хамруулсан.<br>4. Газрын дэргэдэх ёс зүйн дэд хороог газрын даргын 2024 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн А/45 дугаар тушаалаар Ёс зүйн хорооны 2024 оны 05 дугаар тогтоолоор баталсан Ёс зүйн дэд хорооны ажиллах журамд заасны дагуу шинэчлэн байгуулсан. | |
| 13 | А/49 | 2024.04.08 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хувиарт өөрчлөлт оруулах тухай | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 38732689.8 мянган төгрөг, зардалын төлөвлөгөө 117616077.1 мянган төгрөгөөр батлагдсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. | |
| 14 | А/51 | 2024.04.08 | Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо шинэчлэн батлах тухай | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2024.04.08-ний өдрийн "Аймгийн Нийгмийн даатгалын газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоог шинэчлэн батлах тухай" А/51 тоот тушаалаар 50 орон тоогоор батлагдсан бөгөөд Газрын даргын 2024.09.20-ний өдрийн "Ажилтнуудыг ажлаас чөлөөлж, ажилд томилох тухай" Б/55 тоот тушаалаар шинэ бүтэц, орон тоогоор томилон 2024.12.05-ний өдрийн байдлаар 45 албан хаагчтайгаар үйлчилгээ үзүүлж байна. Газарт-4, суманд-1 нийт 5 сул орон тоо байгаа бөгөөд хууль журмын дагуу Завхан аймгийн Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны захиалга өгсөн байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 15 | А/57 | 2024.04.18 | Албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг шинэчлэн тогтоох тухай | Нийгмийн даатгалын газрын 2024.04.18-ний өдрийн "Албан хаагчдын албан тушаалын үндсэн цалинг шинэчлэн тогтоох тухай" А/57 тоот тушаалыг хэрэгжүүлж Газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2024.04.22-ний өдрийн "Цалин шинэчлэн тогтоох тухай" А/14 тоот тушаалаар газрын 45 албан хаагчийн цалинг шинэчлэн тогтоож 2024.04.01-ний өдрөөс мөрдөн ажилласан. | |
| 16 | А/61 | 2024.04.24 | 2024 оныг Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарлах тухай | 2024 оныг "Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил" болгон зарласантай холбоотойгоор 2024 онд нийгмийн даатгалд шинээр хамруулах ажил олгогч, албан журмаар даатгуулагч, сайн дураар даатгуулагчийн тооны төлөвлөг сумын байцаагч нарт хуваарилан хэрэгжилтийг ханган, биелэлтийг тооцон 2024 оны 12 дугаар сарын 05-ний өдөр Шимтгэл хураалтын удирдлага, арга зүйн газарт хүргүүлсэн. | |
| 17 | А/64 | 2024.05.02 | Нийгмийн даатгалын сангийн авлага барагдуулах, ажлыг эрчимжүүлэх тухай | Нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг 2024 оны эхний 869.72 мянган төгрөгний авлагыг 30 хувиар бууруулхаар тусгагдсаныг 763.5 мянган төгрөг буюу 87.79 хувиар бууруулан ажиллаж байна. | |
| 18 | А/67 | 2024.05.07 | Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн хувиарт өөрчлөлт оруулах тухай | Төрийн албаны тухай хууль, Засгийн газрын 2024 оны 83 дугаар тогтоолоор баталсан "Төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-д заасны дагуу аймгуудын Нийгмийн даатгалын газрын төрийн захиргааны албан хаагчдын мөнгөн урамшуулалыг Нийгмийн даатгалын газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн А/67 тоот тушаалаар үйл ажиллагааны урсгал зардлыг төсвийн хуваарьт өөрчлөн оруулсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж, тайлагнан ажиллаж байна. | |
| 19 | А/74 | 2024.05.15 | Мөнгөн урамшуулал олгох тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн "Мөнгөн урамшуулал олгох тухай" А/74 дугаар тушаалын дагуу төрийн захиргааны албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмыг хэрэгжүүлэн ажилласан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 20 | А/75 | 2024.05.15 | Урамшуулал олгох тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн "Урамшуулал олгох тухай" А/75 дугаар тушаалын дагуу нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд, үнэн зөв гаргасан албан хаагчдад урамшуулыг олгож ажилласан. | |
| 21 | А/79 | 2024.05.17 | Болзолт уралдаан зарлах тухай | Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх жил болгон зарласантай холбоотойгоор төлөвлөгөө боловсруулан шинээр ажил олгогч, албан журмын даатгуулагч, сайн дурын даатгуулагч, малчныг хамруулах, мөн нийгмийн даатгалын ач холбогдлыг сурталчилан таниулан ажиллаж байна. | |
| 22 | А/80 | 2024.05.21 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хувиарт өөрчлөлт оруулах тухай | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 38732689.8 мянган төгрөг, зардалын төлөвлөгөө 117766077.1 мянган төгрөгөөр батлагдсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. | |
| 23 | А/83 | 2024.05.21 | Мягтын загвар батлах тухай | Нийгмийн даатгалын шимтгэлийн өртэй байгууллагын банкин дахь дансны зарлагын гүйлгээг түр зогсоож, шимтгэл, алданги төлүүлэх "Мэдэгдэл", дансны зарлагын гүйлгээг нээх "Зөвшөөрөл"-ийн маягтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 24 | А/94 | 2024.05.31 | Аудитын акт, албан шаардлага, зөвлөмж хэрэгжүүлэх тухай | Үндэсний аудитын газраас Нийгмийн даатгалын сангийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүү, нийцлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Зөвлөмжийн биелэлтийг https://fas.audit.mn/-д хугацаанд оруулан тайлагнасан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 25 | А/100 | 2024.06.11 | Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн сарын хувиарыг өөрчлөн батлах тухай | Салбарын нийгмийн хамгааллын хяналтын байцаагчийн томилолтын зардлын төсөв нь "Бараа үйлчилгээний бусад зардал" эдийн засгийн ангилалд байсныг "Дотоол албан томилолт" гэсэн эдийн засгийн ангилал руу шилжүүлсэнтэй холбоотойгоор Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын "Үйл ажиллагааны зардлын 2024 оны төсвийн хуваарьт өөрчлөлт оруулах тухай" А/100 дугаар тушаалаар 1874448.9 мянган төгрөгний төсөв батлагдсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. | |
| 26 | А/130 | 2024.07.16 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн сарын хувиарт өөрчлөлт оруулах тухай | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөө 38732689.8 мянган төгрөг, зардалын төлөвлөгөө 117766077.1 мянган төгрөгөөр батлагдсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан ажиллаж байна. | |
| 27 | А/135 | 2024.09.12 | Унаа хоолны нөхөн төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2024.07.29-ний өдрийн "Унаа хоолны нөхөн төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" А/135 тоот тушаалыг хэрэгжүүлж, газрын 45 албан хаагчид унаа хоолны хөнгөлөлт олгож байна. | |
| 28 | А/137 | 2024.08.05 | Ажил зохион байгуулах тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/137 дугаар тушаалын дагуу аймгийн нийгмийн даатгалын сангийн 2024 оны эхний хагас жилийн санхүүгийн Засгийн газрын нэгтгэл Э-тайланд 2024 оны 08 дугаар сарын 09-ний өдрийн дотор хугацаанд нь оруулж тайлагнасан. Мөн газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрийн Б/01 дугаар тушаалаар батлагдсан ээлжийн амралтын хуваарийн дагуу албан хаагчдын ээлжийн амралт, ээлжийн амралтын цалинг тооцон олгож хэрэгжүүлэн ажилласан. | |
| 29 | А/138 | 2024.08.05 | Төлөвлөгөө батлах тухай | Ажлын төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж төлөвлөгөөний биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт 3 удаа хүргүүлсэн. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 30 | А/153 | 2024.09.12 | Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны тодотгосон төсвийн хувиар батлах тухай | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2024 оны 07 дугаар сарын 29-ний өдрийн "Унаа хоолны нөхөх төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" А/135 тоот тушаалаар унаа хоолны зардал нэмэгдэж 2158148.1 мянган төгрөгөөр үйл ажиллагааны урсгал зардлын төсөв батлагдсан. Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулан  ажиллаж байна. | |
| 31 | А/154 | 2024.09.12 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хувиар батлах тухай | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 45027397.9 мянган төгрөгөөр буюу 106.8 хувиар биелүүлсэн. Зардлын төлөвлөгөө 118036419.5 мянган төгрөг, 117800346.6 мянган төгрөгийг тэтгэвэр тэтгэмжид олгож 99.8 хувийн гүйцэтгэлтэй байсан. | |
| 32 | А/161 | 2024.09.23 | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 09 дугаар сарын 23-ны өдрийн А/161 тоот тушаалаар баталсан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинэ бүрэлдэхүүнээр долоо хоног бүрийн пүрэв гаригт хурлыг зохион байгуулж даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна. | |
| 33 | А/162 | 2024.09.26 | Аян зохион байгуулах тухай | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өрийг барагдуулах, сангийн орлогын төлөвлөгөөг биелүүлэх аяны хүрээнд хуримтлагдсан болон урсгал авлагатай  190 ажил олгогч байгууллагын 675.5 төгрөгийн шимтгэлд дансны барилт хийж ажилласан ба холбогдох данснаас үл маргах журмаар гаргуулан ажилласан. Нийт 175 байгууллагын 657 сая төгрөгийг төлүүлж дансны зарлагын гүйлгээг нээж авлагыг 98.2 хувиар бууруулсан. 40 ажил олгогч байгууллагын 141.2 сая төгрөгийн шимтгэлийн авлагын шүүх байгууллагад шилжүүлсэн ба үүнээс 35 байгууллагын шийдвэр гарч 37.4 сая төгрөгийг төлүүлсэн. Мөн 2 байгууллагыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар шилжүүлсэн. 2023 онд шүүхийн шийдвэр гарч төлөгдөөгүй байсан Ойн баясах ХХК-ний 1.5 сая төгрөгийг бүрэн барагдуулсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 34 | A/169 | 2024.10.03 | Маягтын загвар батлах тухай | Баталсан маягтын дагуу Нийгмийн даатгалын шимтгэлийн өр үүсгэсэн аж ахуй нэгж бүрт тогтмол сануулж, 121 байгууллагад албан мэдэгдэл хүргүүлж, 208 ажил олгогчид харилцах дансны зарлагын гүйлгээг түр зогсоох тухай "Мэдэгдэл"-ийг хүргүүлж 193 байгууллагын дансны зарлагын гүйлгээг нээж, 38 ажил олгогчтой авлага гэрээ байгуулж, хуримтлагдсан болон урсгал авлагын насжилт 271-с дээш хоносон нийт 40 байгууллагын хуулийн байгуулагад шилжүүлж, эзэн холбогдогч нь олдохгүй байгаа 3 байгууллагын удирдлагыг шүүхээр эрэн сурвалжуулах шийдвэр гаргуулж, 3 байгууллагыг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад тус тус шилжүүлж ажиллаж байна. | |
| 35 | A/177 | 2024.10.18 | Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах тухай | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2024.10.18-ний өдрийн "Улсын байцаагчийн шалгалт зохион байгуулах тухай" A/177 тушаалыг хэрэгжүүлж шалгалтад орох байцаагч, мэргэжилтнүүдэд танилцуулан, Нийгмийн даатгалын Ерөнхий газраас зохион байгуулсан сургалтад хамруулж, Шалгалтад бэлдэх нөхцөл боломжоор хангаж ажилласан. Улсын байцаагчийн шалгалтад орох 15 байцаагчаас Нийгмийн хамгааллын хяналтын улсын байцаагч чөлөөлөгдөж, 1 байцаагч хүндэтгэн үзэх шалтгаанаар чөлөө авч 13 байцаагч, мэргэжилтэн шалгалтад хамрагдсан. | |
| 36 | A/179 | 2024.10.22 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн сарын хувиарт өөрчлөлт оруулах тухай | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 45027397.9 мянган төгрөгөөр буюу 106.8 хувиар биелүүлсэн. Зардлын төлөвлөгөө- 119286351.3 мянган төгрөг, 11904778.6 мянган төгрөгийг тэтгэвэр тэтгэмжид олгож 99.8 хувийн гүйцэтгэлтэй байсан. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 37 | А/189 | 2024.10.31 | Албан хаагчдын мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хувь хэмжээнд өөрчлөлт оруулах тухай | Нийгмийн даатгалын газрын даргын 2024.10.31-ний өдрийн "Албан хаагчдын мэргэшлийн зэргийн нэмэгдлийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай" А/189 тоот тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын газрын дарга нарын мэргэшлийн зэргийн хувь хэмжээ"-г батлагдсан хувиар тооцон 2024.10.01-с сар олгож байна. | |
| 38 | А/194 | 2024.11.05 | Мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгох тухай | Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын 2024.11.05-ний өдрийн "Мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгох тухай" А/194 тоот тушаалыг хэрэгжүүлж Нийгмийн даатгалын газрын даргын 2024.11.19-ний өдрийн "Мэргэшсэн эрхийн нэмэгдэл олгох тухай" А/41 тоот тушаалаар Мэргэшсэн эрхийн нэмэгдэл авдаг Тосонцэнгэл сумын Нийгмийн даатгалын тасгийн даргад мэргэшсэн нягтлан бодогчийн эрхийн нэмэгдлийг сарын үндсэн цалингийн 25 хувиар тооцон 2024.11.01-ээс эхлэн сар бүр олгож байна. | |
| 39 | А/199 | 2024.11.11 | Маягтуудын загварыг шинэчлэн батлах тухай | Газрын даргын 2024 оны 11 дүгээр 20-ны өдрийн 537 дугаартай албан бичгээр шинэчлэн баталсан маягтуудыг загвартай сайтар танилцан цаашид ажилдаа мөрдлөгө болгон ажиллах талаар сумдын байцаагч мэргэжилтэнгүүдэд чиглэл өгөн албаны мэйл хаягаар маягтын загварыг хүргүүлсэн. Мөн 2024 оны 11 сарын 23, 24-ний өдрүүдэд зохион байгуулагдсан Нийгмийн даатгалын Улсын байцаагчийн шалгалт өгөх байцаагчдад шинэ загвар маягтын дагуу “Нийгмийн даатгалын байцаагчийн үйлдэх баримт бичиг”-ийн талаар танхимын сургалт хийсэн. | |
| 40 | А/200 | 2024.11.11 | Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 11-ны өдрийн А/200 тоот тушаалаар баталсан Эрүүл мэндийн магадлалын зөвлөлийн шинэ бүрэлдэхүүнээр долоо хоног бүрийн пүрэв гаригт хурлыг зохион байгуулж даатгуулагч, хүний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа, ажлын цаг богиносгох, хөдөлмөрийн нөхцөл солих асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж байна. | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 41 | А/201 | 2024.11.12 | Үйл ажиллагааны урсгал зардлын 2024 оны төсвийн хувиарт өөрчлөлт оруулах тухай | Байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төлөвлөгөө 2150122.1 мянган төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллуудын дагуу зарцуулж, 89761.5 мянган төгрөгийг хэмнэж ажилласан. | |
| 42 | А/202 | 2024.11.12 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн хувиарт өөрчлөлт оруулах тухай | Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд ханган биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 45027397.9 мянган төгрөгөөр буюу 106.8 хувиар биелүүлсэн. Зардлын төлөвлөгөө- 119286351.3 мянган төгрөг, 11904778.6 мянган төгрөгийг тэтгэвэр тэтгэмжид олгож 99.8 хувийн гүйцэтгэлтэй байсан. | |
| 43 | А/217 | 2024.11.29 | Сургалт зохион байгуулах, төсвийн нарийвчилсан хувиар батлах тухай | Сумдаас шинэ хоршоо хөдөлгөөнд хмаргаддаг хоршооны судалгааг авсан ажиллаж байна мөн жижиг дунд үйлдвэрт ажилладаг хувиараа хөдөлмөр эрхлэгдчийг тоо судалгаа сургалтад хамрах боломжийг судалж байна. Хамтран ажиллах сургалт зохион байгуулах мэрэгжлийн байгууллагуудын мэдээллийг авч ажиллаж байна. | |
| *Нийгмийн даатгалын Ерөнхий газрын даргын тушаалын дундаж хувь: 98.9%* | | | | | |